



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/44

Шивээговь сум

“Монгол бичиг”-ийн олимпиад
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Эх хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ын 5.1.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, 2.1.6, тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Үндэсний бичиг, соёлын өдрийг тохиолдуулан Шивээговь сумын Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж буй “Монгол бичиг”-ийн олимпиад зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

- | | |
|-----------------------|---|
| Комиссын дарга: | Ц.Цэрэндорж
(Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч) |
| Гишүүн: | Б.Алтансүх
(Нийгмийн бодлогын мэргэжилтэн) |
| Нарийн бичгийн дарга: | Б.Чулуунцэцэг
(Ерөнхий боловсролын сургуулийн Монгол хэл, бичгийн багш) |

2. “Монгол бичиг”-ийн олимпиадын удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, олимпиадын зардалд зарцуулагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Олимпиадад зарцуулагдах 1,570,000 (нэг сая таван зуун далан мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ)-д зөвшөөрсүгэй.


4. “Монгол бичиг”-ийн олимпиадад иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагуудыг бүрэн хамруулж, өндөр түвшинд зохион байгуулалттай ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Цэрэндорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

Сумын Засаг даргын
2022 оны 04-р сарын 11-ны өдрийн
11/11 Дугаар захирамжийн 1-р хавсралт



ҮНДЭСНИЙ БИЧИГ, СОЁЛЫН ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗДТГ-ААС ЗОХИОН БАЙГУУЛЖ БУЙ
“МОНГОЛ БИЧИГ”-ИЙН ОЛИМПИАДЫН УДИРДАМЖ

Үндэслэл: Монгол улсын ерөнхийлөгчийн 105 дугаар зарлиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, Монгол хэлний тухай хууль, Монгол бичгийн үндэсний хөтөлбөр- 3-ыг хэрэгжүүлэх, Үндэсний бичгийн хэрэглээг олон нийтийн хүртээл болгож, хос бичигтэн болох. үндэсний өв соёлоо хамгаалж хөгжүүлэх, “Үндэсний бичиг үсгийн баяр” ын арга хэмжээг угтан зохион байгуулна.

Зорилго: Үндэсний бичгийн хэрэглээг өргөтгөж, сургалтын орчин, сургах боловсон хүчний чадавхыг нэмэгдүүлэх, иргэдийн идэвх, сонирхлыг дэмжин, үндэсний бичгээ сурталчлах, түгээн дэлгэрүүлэх.

Хугацаа: 2022 оны 04 дүгээр сарын 26

Хамрах хүрээ:

-Төрийн байгууллага

-Иргэд

Зохион байгуулах газар: Шивээговь сумын Ерөнхий боловсролын сургууль, “эх хэлний танхим”-д

Шагнал:

Төрийн албан хаагч

I байр мөнгөн шагнал 1 50.000 төг

II байр мөнгөн шагнал 1 40.000 төг

III байр мөнгөн шагнал 1 30.000 төг

Иргэн

I байр мөнгөн шагнал 1 50.000 төг

II байр мөнгөн шагнал 1 40.000 төг

III байр мөнгөн шагнал 1 30.000 төг

Сумын Засаг даргын
2022 оны 04-р сарын 11-ны өдрийн
Дугаар захирамжийн 2-р хавсралт



“МОНГОЛ БИЧИГ”-ИЙН ОЛИМПИАДЫН ТӨСӨВ

	Нэр	Зориулалт	Тоо (ширхэг)	Ширхэгийн мөнгөн дүн	Нийт
ЕБС-ийн бага, дунд ахлах анги, багш нар					
1	I байр мөнгөн шагнал	Бага, дунд, ахлах анги	3	150.000 төг	450.000 төг
2	II байр мөнгөн шагнал	Бага, дунд анги	2	130.000 төг	260.000 төг
3	III байр мөнгөн шагнал	Бага, дунд анги	2	110.000 төг	240.000 төг
4	I байр мөнгөн шагнал	Багш	3	40.000 төг	120.000 төг
5	II байр мөнгөн шагнал	Багш	2	30.000 төг	60.000 төг
6	III байр мөнгөн шагнал	Багш	2	20.000 төг	40.000 төг
Төрийн албан хаагчид					
7	I байр мөнгөн шагнал	ТАХаагч	1	50.000 төг	50.000 төг
8	II байр мөнгөн шагнал	ТАХаагч	1	40.000 төг	40.000 төг
9	III байр мөнгөн шагнал	ТАХаагч	1	30.000 төг	30.000 төг
Иргэд					
10	I байр мөнгөн шагнал	Иргэн	1	50.000 төг	50.000 төг
11	II байр мөнгөн шагнал	Иргэн	1	40.000 төг	40.000 төг
12	III байр мөнгөн шагнал	Иргэн	1	30.000 төг	30.000 төг
Бичиг хэргийн зардал					
13	Бичгийн цаас	Олимпиад материал	3 боодол	20.000 төг	60.000 төг
14	Өргөмжлөл	Бүгд	20	5.000 төг	100.000 төг
Нийт					1.570.000 төг